

### БНХАУ-ЫН ҮНДЭСНИЙ ЗАРИМ РАЙОНЫ СҮҮЛИЙН ҮЕИЙН БАЙДАЛ

О. Чулуун.

БНХАУ-ын бүх хүн амын 94 хувь нь хан үндэстэн, 6 хувь нь хятад биш ард түмэн юм. Хятад биш ард түмний газар нутаг нь бүх хятадын газар нутгийн 60 орчим хувийг эзлэнэ. Хятад биш 55 угсаатан ястанд хятадын хэвлэлийн 1981 оны мэдээгээр 55 сая 800 мянган хүн хамаарагдаж байна. Эдгээр хятад биш ард түмэн одоо хүртэл үндэсний тэгш эрхээр хангагдаж чадаагүй бөгөөд тэнд олны анхаарлыг татсан янз бүрийн хэрэг явдал удаа дараа гарч байна. Энэ учраас дэлхий дахины хятад судлаачид уг асуудлын талаар бодит баримтанд тулгуурлан судалгаа шинжилгээний бүтээл гаргах нь цөөнгүй болжээ.

Энэ удаа БНХАУ дахь хятад биш бүх ард түмний талаар авч ярихгүй. Харин Төвд, Синьзяны автономит район болон Өвөр Монголын өөртөө засах орны доторхи уйгур, хасаг, монгол зэрэг угсаатан ард түмний сүүлийн үеийн байдлыг товчоор хөндөн өгүүлнэ.

Дээрх гурван автономит районы доторхи хятад биш ард түмний зарим нь манай монголчуудтай түүх, соёл, газар нутаг, удам угсааны шууд холбоотой юм.

Ийм ч учраас манай монголын эрдэмтэд БНХАУ-ын дээрх гурван автономит район, ялангуяа Өвөр Монголын Өөртөө Засах орны байдлыг судалж, өөрийн дүгнэлтийг хийж байдаг юм. Тэгэхдээ, бид бусдын дотоод хэрэгт оролцох замаар биш, аливаа улс, ард түмний түүхийг эрдэмтэд судалдгийн нэгэн адил хэмжээнд судлан шинжилж, уг асуудлыг хятад судлалын салшгүй нэгэн хэсэг гэж үзэж байна.

#### I

БНМАУ-д анхлан Төвдийн талаар судалгаа явуулахдаа гол төлөв Монгол Төвдийн харилцаа ялангуяа соёлын харилцааны түүхэн уламжлал болон Буддийн судлалтай холбогдсон асуудлыг голчлон анхаарч ирэв. Энэ талаар манай улсад нилээд зохиол бүтээл гарсан бөгөөд төвд хэл дээр бичигдсэн арвин их ном материал БНМАУ-ын номын санд хадгалагдаж байна. Эдгээр арвин хэрэглэгдэхүүнийг ашиглан манай эрдэмтэд шинжилгээ судалгааны ажил хийж байгаа бөгөөд академич Ц. Дамдинсүрэн, Ш. Бира, доктор Ч. Жүгдэр, Д. Пүрэвжав нарын зэрэг олон эрдэмтний бүтээлийг дурдаж болох байна.<sup>1</sup>

<sup>1</sup>Ц. Дамдинсүрэн. «Исторические корни Гесериады» М., 1957. «Цагаан дар-эх ба ногоон дар-эхийн туужууд» УБ, 1958. «Субашид» УБ., 1958. «Рамаяна Монголд дэлгэрсэн нь» УБ., 1976. Ш. Бира. «Монгольская тибетоязычная историческая литература»—(XVII—XIX вв), УБ., 1960 «О золотой книге Ш. Дандина», УБ, 1964. Ч. Жүгдэр. «3. Агваанбалдангийн гүн ухааны үзэл» УБ., 1973. С. Пүрэвжав. «Монгол дахь шарын шашны хураангуй түүх» УБ, 1978. Б. Ринчин «Үүлэн зардас» УБ. 1978.

П. Алтангэрэл «Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл» I, II УБ., 1967, 1.968. Ер нь төвдийн судлалаар манай улсад 60 гаруй ном, 200 гаруй өгүүлэл нийтлэгджээ.

1951 оноос хойш буюу Хятад Ард Улс цэргээ Төвд руу оруулж түүнийг хүчээр нэгтгэсэн цагаас эхлэн Төвд орон, ялангуяа төвд ард түмэн хятадын удирдагчдын жанжлах бодлогод хэрхэн өртөж, маогийнхнаас тэдгээр ард түмний түүх, соёлын дурсгалыг эвдэн сүйтгэж, шашин шүтлэгийг нь хавчин гадуурхаж байгааг судлах ажлыг манай эрдэмтэд хийж эхэлсэн. Бидний судалгааны товч үр дүн болсон дэд эрдэмтэн Д. Маамын бичсэн «Маогийнхны бодлогод хэлмэгдэж байгаа Төвд орон» хэмээх бүтээл 1974 онд мөн Төвдийн байдлаар хэд хэдэн өгүүлэл нийтлэгдэв.

БНХАУ-д нийтдээ 6 сая орчим төвд хүн амьдарч байх ёстой гэж Далай ламын төлөөлөгчид мэдэгдсэн билээ. Гэтэл хятадын өөрсдийнх нь мэдээгээр бол Төвд, Цинхай, Сычуань, Ганьсу, Юньнань зэрэг муж, өөртөө засах оронд 1978 онд 3 сая 415 мянга,<sup>2</sup> одоо 3 сая 400 мянган<sup>3</sup> төвд хүн амьдарч байгаа ажээ. Эдгээрээс одоо Төвдийн автономит районд 1 сая 300 мянган төвд хүн амьдарч байгаа бололтой. Төвдийн автономит районы нийт хүн ам одоогоор тодорхойгүй байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хятад хүний хувийн жин эрс нэмэгдэж байгаа ажээ. Төвдийн автономит районы хөгжил, ард түмний аж амьдрал, соёлын түвшин дорой хэвээр, өөрөөр хэлбэл одоогоос 20 жилийн өмнөхөөс ч доогуур байгаа бололтой. Энэ байдлыг сүүлийн үеийн хятадын хэвлэлийн материал, Далай ламын бие элч Төвдөд очиж, тэндхийн амьдралтай танилцаж ирээд гаргасан мэдэгдэл болон гадаадын хэвлэлийн зарим мэдээ сэлт тодорхой гэрчилж байна. Бээжинд суугаа гадаадын сурвалжлагчид, түүний дотор БНМАУ-ын сурвалжлагч 1979 онд Лхас хотод очиж төвдийн байдалтай танилцахад тэндхийн төвд ард түмний амьдрал ихээхэн хоцрогдмол хэвээр байсан байна.

1960-аад оны дунд үеэс маогийн бүлгийнхэн Төвдийн автономит районы дотор нугалаа завхрал гаргаж, төвд хүмүүсийг гадуурхан хавчих нь их болж, тэр ч байтугай төвд охидыг хятад хүнтэй албан хүчээр гэр бүл болгож байсныг сүүлийн үед хятадын хэвлэл ч зөвшөөрөн хүлээх болов.<sup>4</sup>

Хятадын Коммунист Намын Төв Хорооны дарга Ху Яобан 1981 оны тавдугаар сард Төвдөд очсон тухай хятадын хэвлэлийн мэдээнээс үзсэн ч Төвд хүмүүсийн байдал хоцрогдсон, амьдрал нь дорой байгаа болох нь бас тодорхой байна. Төвдийг сүйтгэж байсан тухай ганц баримтыг дурдвал: 1959—1963 онд барагцаалбал 200 мянган хүн алагдаж, зарим нутагт бүхэл бүтэн тосгоныг шатааж байсан байна.<sup>5</sup>

Одоо хятадын эрх баригчид дээрх нугалаа завхрал, алдаатай бодлогоо цагаатгах гэж янз бүрийн арга мэх хэрэглэж байна. Тухайлбал, Төвдийн эдийн засгийг хөгжүүлэх, соёлыг сэргээх, сүм хийдийг сэлбэн засах, сургуульд төвд хэлээр хичээл хийдэг болгох зэрэг арга хэмжээ авч байгаа юм. 1978 оны байдлаар Төвдийн автономит районы 6212 бага сургуульд 206300 сурагч, 75 дунд ба тусгай мэрэгжлийн сургуульд 21700 сурагч, дөрвөн их дээд сургуульд 2081 оюутан тус тус сурч байна гэж хятадын хэвлэл 1981 онд мэдээлэв. Энэ бол үнэндээ бас л жинхэнэ төвд хүний үр хүүхэд суралцаж байгаа гэсэн хэрэг биш ээ. Ер нь хятадын эрх баригчдын сүүлийн үед үйлдэж буй иймэрхүү ажил явууллага нь төвд угсааны ард түмнийг бүгдийг ий нэгтгэн, үндэсний онцлогийг харгалзан цэцэглүүлэн хөгжүүлэх гэсэнд биш, харин төвдийн ард түмний

<sup>2</sup>«Хятадын цөөн тоот үндэстнүүд», Бээжин, 1981. 257 дугаар тал.

<sup>3</sup>Ван Дэ «Нацменьшинства китай» «Жунго хуа бао»—(«Ардын зурагт сэтгүүл»), 1981, № 1.

<sup>4</sup>«Жэньминь жибао» 1980. IX. 10.

<sup>5</sup>«Адзия дайгаку Адзия кенкюсёхо» 1980. II. 13.

эсэргүүцэл тэмцлийг түр ч болтугай намжаах гэсэн бодлого юм. Иймээс 1980-аад онд Төвдийн автономит район хоцрогдсон бөглүү хязгаар нутгийн байдалтай хэвээр байж, төвд ард түмний амьдралд нааштай мэдэгдэхүйц өөрчлөлт гарч чадахгүй төлөвтэй байна. Сүүлийн үед Төвдийн нутгийг хятадын цэргийн цөмийн зэвсгийн бааз болгож байна. Төвдийн Нагчу хэмээх уулархаг районд Энэтхэгийн эсрэг чиглэсэн 950 км тусгалтай 70 гаруй пуужин, 2400 км-ийн тусгалтай 20 балластик пуужинг байрлуулжээ.<sup>6</sup> Энэ байдлаас үзэхэд ч гэсэн 1980-аад онд хятадаас Төвдийн талаар явуулах бодлогод чанарын өөрчлөлт нэг их гарахгүй, төвдийн нутгийг хөрш орнуудын эсрэг чиглэсэн цэргийн бааз газар хэвээр байлгасаар байх нь тодорхой байна. Мөн төвд үндэстэн хятадын олон мужид хуваагдан тархай бутархай байдалтай оршин сууж, төвдийн ард түмэн аанай л хятадын жанжлагчдын их гүрний дээрэнгүй бодлогод урьдын адил өртөгдөн ямар ч эрх чөлөөгүй хэвээр байх төлөвтэй байна.

## 2.

Синьзян-Уйгарын автономит район (СУАР) нь БНХАУ-ын бүх газар нутгийн зургааны нэг хувь буюу 1 сая 600 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, 12 сая гаруй хүн амтай.<sup>7</sup> Автономит районд 5 сая 418 мянган уйгур хүнээс гадна 700 мянга шахам хасаг хүн мөн нилээд олон тооны хотон (хуй), монгол хүн оршин сууж байна. Бас узбек, тажик, киргиз, татар, манж, орос зэрэг ястан угсаатан оршин суудаг. Сүүлийн үед тэнд оршин суух хан үндэстний тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Хятадын эрх баригчдаас уг районыг хамгийн их чухалчилан үздэгийн учир гэвэл ЗХУ, Афганистан, Энэтхэг, Пакистантай шууд хил залгадагт оршино.

Мөн Синьзян-Уйгурын автономит район нь манай улсын баруун аймгуудтай шууд хиллэдэг. Ялангуяа энэ автономит районд оршин суудаг уйгур, хасаг, монгол хүмүүсийн ах дүү, төрөл төрөгсөд манай улсын Баян-Өлгий аймагт амьдарч байна. Одоогийн байдлаар Монгол-Синьзяны хооронд ямар ч сайн хөршийн харилцаа алга. Синьзян-Уйгурын ард түмний үндсэн уугуул нутаг дэвсгэрийг хятадын эрх баригчид ЗХУ болон бусад хөрш орны эсрэг дайны талбар болгон хувиргаж, эдийн засгийг нь цэргийн хэрэгцээнд зориулан сүйтгэж, байгалийн баялгийг нь их хэмжээгээр олзборлон авч байна. Хятадын баруун хойд талд ажиллаж байгаа дөрвөн реакторын хоёр нь тус автономит районы төв Урумчид байгаа ажээ. Тэрчилэн ураны хүдрийн баяжуулах заводыг Урумчид, плутон цэвэрлэх заводыг Шахьяарт байгуулан ажиллуулж байна.

Гадаадын хэвлэлийн мэдээгээр хятадын атомын шинжилгээний төв нь СУАР-ны Хами хотод төвлөрсөн байна. Хами хотоос баруун тийш 250 км оршдог Лоб нуурын районд цөмийн зэвсгийн туршилтын талбайг 1963 онд байгуулсан билээ.

Туршилтын энэ талбайг байгуулахад 40 сая доллар зарцуулсан бөгөөд сүүлийн жилүүдэд жилийн дундач зардал нь 20 сая доллар болж байгаа ажээ. Сүүлийн үед Синьзяны нутаг дахь цөмийн баазыг улам өргөтгөн, цэргийн хяналтын дор байлгаж, тэнд зөвхөн хятадуудыг л ажиллуулж байна. Энэ бүхэнд Синьзяны хятад биш ард түмэн дургүйцэж эсэргүүцэл илэрхийлэх, зарим нэг нутагт бослого хөдөлгөөн хүртэл гарсаар байгаа нь 1981 оны зарим мэдээгээр ч бүр тодорхой болсон юм.

Бээжингээс Азийн өмнөд болон баруун хэсэгт явуулж байгаа цэрэг стратегийн түрэмгий бодлого, юуны өмнө Энэтхэг, Афганистаны эсрэг

<sup>6</sup>«Хятадын цөөнх тоот үндэстнүүд», 276 дугаар тал

<sup>7</sup>«Улаан од» 1980, № 142.

явуулах бодлогод Синьзяныг Кашмиртай холбосон Каракорумын зам чухал үүрэг гүйцэтгэж байна. Уг засмал замын урт 800 км, өргөн нь 12 м, гүүрийн даац нь 40—50 тонн бөгөөд замын ойр орчимд агуулах, станц, шатахуун түгээгүүрийн газар олныг барьсан байна.<sup>8</sup> Үүнээс үзэхэд энэ зам нь айл зэргэлдээ орны эсрэг түрэмгийлэл үйлдэх зорилттой болох нь тодорхой байна.

Синьзянд цэрэг дайны зориулалттай олон уурхай, үйлдвэр байгуулсан явдал нь энэ районы уугуул ард түмний улс төр, эдийн засаг, соёлын амьдралд хэмжээлшгүй их хохирол учруулсаар байна. Бээжин сүүлийн үед зарим иргэний аж үйлдвэрийн газрыг цэргийн зориулалттай болгож байна. Гадаадын хэвлэлийн мэдээнээс үзэхэд саяхан Синьзяны авто засварын заводад их бууны гол төмөр үйлдвэрлэх болжээ.

1978 онд Синьзянд очсон Английн сурвалжлагч бичихдээ: «Энэ районд хоцрогдсон эдийн засаг, цөмийн зэвсэг турших талбараас бүрдсэн хоёр зүйлс орчин үед зэрэгцэн, өргөн хэмжээгээр цэрэгжүүлэх ажил явагдаж байна»<sup>9</sup> гэжээ. СУАР-д ХАЧА-ийн үлэмжийн их цэргийн ангиуд байрлаж байгаагийн дээр, гол төлөв хуучин цэргийн албан хаагчдаас бүрдсэн 1,5 сая хүнтэй үйлдвэрлэл бригадын корпус гэгчийг байгуулжээ. Энэ нь нутгийн оршин суугчдын дургүйцлийг хүргэж байсан учир нэрийг нь өөрчлөн өрхийн цэргийн системд хамааруулан, сангийн аж ахуй гэгдэх болсон боловч аанай л цэрэгжсэн хэвээр байна. Үүнтэй холбогдуулж 1978 оны аравдугаар сарын 19-нд «Санди таймс» сонинд бичсэн нь: «Тэр нэг сангийн аж ахуй нь барагцаалбал 40 мянган хүнтэй бөгөөд 15 мянга нь автоматаар зэвсэглэсэн байна. Тэнд буудлага хийх, мина тавих, гранат шидэхэд сургах газар бий болгосон байна» гэжээ. 1980-аад онд Синьзяны нутаг дэвсгэрийг хөрш улсын эсрэг цэргийн бааз газар хэвээр байлгаж тэнд цэргийн үйлдвэрлэлийг их хөгжүүлэх төлөвтэй байна. Тус автономит районы хятад биш ард түмний аж амьдралын хэмжээ дорой хэвээр байх нь гарцаагүй байна.

### 3.

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны байдал ч дээрх хоёр автономит районы байдлаас ялгагдах юм ер алга.

1947 оны тавдугаар сарын 1-нд ӨМӨЗО байгуулагдахад газар нутаг нь 500 мянган хавтгай дөрвөлжин км, хүн ам нь 2 сая орчим байв. 1950-онд Өвөр Монголын газар нутаг 1 сая 400 мянган хавтгай дөрвөлжин км болж, хүн ам нь жилээс жилд нэмэгдэх болов. Үүнд: 1955 онд 6 сая 100 мянга, 1960 онд 10 сая, 1967 онд 13 сая хүн амтай болов. Энэ нь Өвөр Монголд хятад хүний тоо эрс олон болж, харин жинхэнэ өвөр монгол хүний өсөлтийн хувийн жин огт нэмэгдэхгүй байв. Хятадад 1978 оны байдлаар 2 сая 600 мянган<sup>10</sup> монгол хүн байсны ихэнх нь ӨМӨЗО-нд амьдарч байв. Энэ оны байдлаар ӨМӨЗО 1 сая 170 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, 18 сая хүн амтай болсон байна. Үүнээс жинхэнэ монгол хүн 1 сая 300 мянга орчим ажээ. Засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчлөх нэрийдлээр 1949-1980 онд ӨМӨЗО-ны нутаг дэвсгэрээс хятад мужуудад шилжүүлэх, мөн хятад мужуудаас Өвөр Монголд газар нутаг нийлүүлэх зэргээр тус районы нутаг дэйсгэрт 6 удаа (1950, 1954, 1955, 1957, 1970, 1979) өөрчлөлт хийжээ. Өвөр Мон-

<sup>3</sup>«Үнэн», 1979—XII—27.

<sup>9</sup>«Улаан од» 1980. № 42.

<sup>10</sup>«Хятадын цөөнх тоот үндэстнүүд» 68 дугаар тал.

голд хүн ам үлэмж нэмэгдсэн нь үүнтэй шууд холбоотой юм. Хятад хүмүүсийг үндэстний районд ийнхүү олноор оруулсан нь Маогийн «Олон хүн оломгүй далай»—(«Жаньхай жань шу») гэдэг тактиктэй шууд холбоотой юм. Өөрөөр хэлбэл хүн ам цөөнтэй монголчууд олон хятад хүнтэй хутгалдана гэдэг нь оломгүй далайд унасантай адил хэрэг билээ. Одоогийн байдлаар ӨМӨЗО нь Улаанцав, Шилийн гол, Зуу Уд, Их Зуу, Жирэм, Хөлөнбуйр, Баяннуур, Алаша, Хянган эдгээр есөн аймаг, 35 хошуунаас бүрдэж байна. Өвөр Монголд оршин суугаа хятад хүмүүс үлэмж хэмжээний атар газрыг хагалж, аль үржил шимтэй хөрсийг эзэмшин, малын бэлчээрийг устгаж байна. Өөрөөр хэлбэл Өвөр Монголын үржил шим сайтай малын бэлчээрийн тэн хагас нь одоогийн байдлаар тариалангийн талбай болсон бөгөөд цаашид энэ байдал улам даамжран үргэлжлэх төлөвтэй байна.

Өвөр Монголын Хорин гэр хэмээх газарт нүүрсний уурхай нээснээс болж, эндхийн 800 мянган толгой мал бэлчээргүй болж, эзэмшсэн бэлчээр нутгийн оронд нэг ч улаан мөнгө малчдад өгөөгүй ...Уурхай байгуулж буй чөлөөлөх армийн цэргүүд атар газрыг дур зоргоороо эзэмшиж, бэлчээрийг сүйтгэх явдал цэрэг ардын найрамдал, малчин ардын амьдралд нөлөөлөөд зогсоогүй мал аж ахуйг хөгжүүлэхэд хор холбогдолтой болж байна гэж хятадын хэвлэл мэдээлэв.<sup>11</sup>

1976 оны байдлаар ӨМӨЗО нь 23 сая малтай байв. 1980-аад оны эхний байдлаар Өвөр Монгол 40 сая малтай болсон гэж хятадын хэвлэл мэдээлж байна. Энэ тоонд бидний үзэж байгаагаар гахайг оролцуулсан бололтой. Гэтэл үнэндээ Өвөр Монголын таван хошуу малын тоо өсөхгүй байгаа юм. Энэ нь монгол малчдын мал маллах сонирхол ихэд буурсантай шууд холбоотой юм. Энэ байдлыг мэдэж ойлгосны үндсэн дээр сүүлийн үед хятадын эрх баригчид монгол малчдын мал маллах авьяас, хөдөлмөрийг ашиглах гэж нилээд арга хэмжээ авч байна. Энэ нь чухам ямар үр дүнд хүргэхийг хэлэхэд хэцүү юм. Ямар ч гэсэн их хан үндэстний дээрэнгүй жанжлах үзэлтнүүдэд Өвөр Монголын малчин ардууд дуртай биш билээ.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд зөвхөн Шилийн гол аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэл 9 удаа хорогдсоны 8 нь «соёлын хувьсгал»-ын хэрэг явдалд өртсөнтэй холбоотой юм. Улс төрийн компаниуд явагдсан эдгээр жилүүдэд малын нийт тоо толгойн тал хувь нь хорогдож ноцтой хохирол учирсан байна.<sup>12</sup>

Өвөр Монголд жилд дунджаар 70 мянган тонн янз бүрийн ноос, 300 мянга гаруй ширхэг арьс шир бэлтгэдэг боловч тэдгээрийн гуравны хоёрыг хятадын бусад орон нутаг руу авч явдаг тул тус район нь хэрэг дээрээ түүхий эд,хагас бүтээгдэхүүний бааз болон хувирчээ. Өвөр Монголын Өөртөө Засах орны хөдөө аж ахуй иймэрхүү байдалтай байна. Харин энэ районд нэг салбар туйлын эмх цэгцтэй байна. Тус өөртөө засах орны Бугат хотоос баруун тийш 6 км зайтай газарт атомын реактор байгуулжээ. Жилдээ 10 кг плутон боловсруулах чадалтай энэ үйлдвэр одоо улам өргөжиж байна. Гадаадын хэвлэлийн мэдээнээс үзвэл хятадууд залуурт пуужин ба цөмийн нөөцөө Манжуурын хойт хэсэг, Өвөр Монголын нутагт шилжүүлж байгаа ажээ.

Хятадын үндэсний районуудад улс ардын аж ахуй, соёлын үлэмжийн их гачигдал бэрхшээлтэй байгааг харгалзахгүйгээр Бээжингийн эрх баригчид дээрх районуудад цэрэг дайны бэлтгэлийг хүч хөрөнгө хайрлахгүй эрчимтэй хийсээр байна. Хятадын эрх баригчид ялангуяа ӨМӨЗО-ны нутаг дэвсгэрийг БНМАУ-ын эсрэг дайн түрэмгийлэл

<sup>11</sup> «Жэньминь жибао» 1980. IX. 15.

<sup>12</sup> «Жэньминь жибао» 1980. IX. 15.

үйлдэх түшиц газар болгон ашигласан хэвээр байна. 1965 оноос хойш хятадын тал манай улсын хилийг 400 гаруй удаа зөрчиж, манай улсын хилийн орчимд 87 мянга гаруй удаа тэсэлгээ, дэлбэлэлт хийжээ. Мөн манай улсын хилийн ойролцоох районд хятадын цэргийн ангиуд томоохон хэмжээний хээрийн сургууль 350 удаа хийсэн байна. Мөн Эрээний төмөр замын станцын салалтыг 32 хүртэл нэмжээ. Москва-Улаанбаатар-Бээжингийн төмөр замын ачаа тээврийн хэмжээ доод хэмжээнд байгаа өнөөгийн нөхцөлд Монгол-Хятадын хилийн станц Эрээнд салаа замыг ийнхүү нэмсэн нь цэргийн зориулалттай байгааг бүрэн баталж байна.

Мөн хятадын эрх баригчид Өвөр Монголд газар дор том хэмжээний цэргийн төхөөрөмж байгуулж байна. Тэрхүү төхөөрөмжийн хонгилоор хөнгөн танк, жижиг автобус чөлөөтэй явах боломжтой ажээ. Энэ тухай Өрнөд Германы Бундестагийн төлөөлөгч Хятадад аялсан тухай мэдэгдэлдээ 1976 оны гуравдугаар сарын 2-нд тэмдэглэсэн байна.

Бээжингийн өнөөгийн удирдлага Өвөр Монголоор бүх монголыг төлөөлүүлэхийг оролдож байгаа юм. Энэ зорилгын үүднээс монгол судлалыг «хөгжүүлэх» талаар зүйл бүрийн арга хэмжээ авч байна. Монгол судлалын олон тооны төвүүдийг байгуулж, түүхийг завхруулан гуйвуулах замаар монголчуудыг хэзээнээс хятадын цөөнх үндэстэн «Жунхуа миньзу»-гийн нэг бүрэлдэхүүн хэсэг гэж нотлохыг оролдож байна. Үүнийг Өвөр монголчуудад итгүүлэхийн тулд тэдний дунд үндсэрхэг үзлийг дэвэргэх арга замд шилжин орж монголын түүхийг гуйвуулж байна.

Цаашид Өвөр Монголыг хятадын эрх баригчид чухам ямар байдалтай байлгах бол гэдэг асуудал бидний анхаарлыг татсаар байгаа юм. Юуны өмнө тус өөртөө засах орны хятад хүний хувийн жин эрс нэмэгдэж, Өвөр Монгол хятад мужийн байдалтай болох төлөвтэй байна. Өвөр Монголын эдийн засаг нь цэрэг дайны байдалд зориулагдаж, цэргийн бааз газар болох нь бидэнд бүр ч ойлгомжтой болж байна.

х х х

1980-аад оны эхэн үеийн байдлаас үзвэл БНХАУ нийгэм-улс төр, эдийн засаг, үзэл суртлын гүнзгий хямралд автагдсан хэвээр байгаа бөгөөд бээжингийн эрх баригчид энэ хямралыг бүрмөсөн гэтлэн давах дотоод, гадаад бодлогын зөв чиг шугамыг боловсруулж чадахгүй байна. Иймээс БНХАУ-ын доторхи хятад биш ард түмний нийгэм-улс төр, эдийн засаг, соёлын хөгжилд 1980-аад онд дорвитой ахиц гарч чадахгүй төлөвтэй байна.

## СОВРЕМЕННОЕ ПОЛОЖЕНИЕ В НАЦИОНАЛЬНЫХ РАИОНАХ КНР

(Резюме)

**О.Чулуун**

Больше половины территории Китая заселено национальными меньшинствами. Социально-экономическое положение неханьских народов было и остается объектом исследования ученых-китаеведов. Данная статья посвящена национальной политике китайского руководства в отношении

народов трех автономных районов КНР-Тибета, Синьцзяно-Уйгурского автономного района и Внутренней Монголии.

Характерными чертами современного Тибета являются низкий жизненный уровень основного населения, безграмотность, отсутствие социальных благ, превращение Тибета в военный плацдарм против соседних стран.

Синьцзяно-Уйгурский автономный район (СУАР) занимает важное стратегическое положение в гегемонистской политике пекинского руководства. Он граничит с СССР, Афганистаном, Индией, МНР. На его территории имеются залежи многих полезных ископаемых, в том числе и стратегического значения.

В последнее время на территории СУАР были построены и размещены большое количество заводов, связанных с военным производством, построен полигон для испытания ядерного оружия, проложены дороги стратегического назначения, произведена перестройка экономики на военные нужды.

Это не может не вызывать растущей тревоги у местного населения. СУАР является самым «неспокойным» районом КНР. Частые демонстрации, забастовки, массовые волнения выражают недовольство низким жизненным уровнем и политикой правительства доведенных до отчаяния народных масс этого автономного района.

С политикой ассимиляции и растворения местных жителей среди китайцев было связано, проводимое под предлогом административных изменений, присоединение некоторых районов Внутренней Монголии к китайским областям. За последние 30 лет такие изменения в территориальном отношении проводились 6 раз.

Эти мероприятия, а также «разработка» экономических ресурсов Внутренней Монголии пагубно отражаются на животноводстве-основной отрасли экономики этого автономного района. Хроническое уменьшение поголовья домашних животных, падение заинтересованности у местных жителей в разведении скота, плохое их материальное обеспечение характеризуют обстановку, сложившуюся во Внутренней Монголии.

Особое место в политике центрального китайского руководства во Внутренней Монголии занимает использование ее территории как плацдарм для проведения провокационных действий и идеологических диверсий против МНР.

В Пекине до сих пор не отказываются от мысли присоединить МИР к Китаю. Внутренняя Монголия выставляется как бы центром всей Монголии. С этой целью во Внутренней Монголии принимаются меры для «развития» монголоведения, целью которого преследуется доказательство принадлежности монгольской нации к китайской «Чжунхуа минь зу».

В 80-е годы вряд ли что-либо изменится в социально-экономическом развитии автономных районов. Растущее недовольство народных масс, превращение автономных районов в сырьевые придатки и военные плацдармы против соседних стран, низкий жизненный уровень населения есть пагубные последствия национальной политики китайского руководства.